

# ХОВД АЙМГИЙН ХӨТӨЧ НОМ





# ХОВД

## АЙМГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА МЭДЭЭЛЭЛ

БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчдийн 1931 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 05 дугаар хурлын тогтоолоор 13 сумтай байгуулжээ.

Аймгийн төв: Ховд хот

Сумын тоо: 16

Нутаг дэвсгэрийн хэмжээ: 76,060.38 км<sup>2</sup>

Хүн амын тоо: 89,712 (2020 он)

Гадаадад оршин суугаа 1,758, гаднаас оршин суугаа 121+3

Угсаатан: Халх, Торгууд, Захчин, Өөлд, Дөрвөд, Мянгат, Хошуут, Урианхай, Казак, Тува, Баяд, Буриад

Малын тоо толгой: 3,292,580 (2020 он)

Утасны код: +976 (0) 143

Шуудангийн дугаар: 84000

Техникийн улсын дугаар: ХО

Цахим хуудас: <http://khovd.gov.mn/>

Ховд аймаг нь Монгол орны баруун урд хэсэгт Алтайн нуруу Монгол Алтайн их уулст оршино. Энд Мөнххайрхан, Хөхсэрх, Баатар хайрхан, Мянган Угалзат зэрэг том уулс бий бөгөөд аймгийн нутгийн 20 орчим хувийг говь тал эзэлнэ.

Ховд аймгийн нутгаар Ховд гол, Буянт гол, Булган гол, Чонохарайх гол, Цэнхэр гол зэрэг том голууд урсах бөгөөд Хар-Ус нуур, Хар нуур, Дөргөн нуур, Цэцэг нуур зэрэг том, жижиг нуурууд оршдог. Нэвтийн рашаан, Булганы рашаан, Индэртийн рашаан зэрэг рашаан ус олон бий.

Нэн өвөрмөц, нийтдээ 1300 орчим зүйлийн ургамал ургадаг. Монгол улсын улаан номонд бүртгэгдсэн 86 зүйл ургамалын 25 нь энд багтдаг. 5 аймгийн 633 гаруй зүйлийн сээр нуруутан байдгаас 90 зүйл хөхтөн, 220 гаруй зүйл шувуу, 11 зүйл хэвлээр явагч, 8 зүйл загас, нэг зүйл хоёр нутагтан бий. Аймгийн олон суманд хүнсний ногоо тухайлбал амтат гуа, тарvas тариалдаг. Булган суманд Монголдоо ховор жимс тариалдаг. Ховд аймагт Хятад улс руу гарах хилийн боомт Ярант, Байтаг хоёр Булган суманд байдаг юм. говьд аргаль, янгир, цагаан зээр, хар сүүлт, хойлог зэрэг ан амьтан элбэгтэй бөгөөд дэлхийн улаан номонд бичигдсэн дархан цаазат хулан, ирвэс ч байдаг.







Ховд хот нь Ховд аймгийн төв юм. Жаргалант сум, Ховд хот нь далайн түвшнээс дээш 1405 метрийн өндөрт оршдог. Эх газрын шинжтэй эрс тэс уур амьсгалтай. Чийгийн үзүүлэлтээрээ хуурай дулаавтар, уул хээрийн мужид байдаг. Улаанбаатар хотоос 1450 км, аймгийнхаа бусад сумаас 25-375 км зайтай. Буянт, Ховд, Дуут сумдтай хил залгаа оршдог.

Өрхийн тоо: 7,9 мянга

Хүн амын тоо: 30,8 мянга

Улаанбаатар хотоос алслагдсан зай: 1450 км





ХОВД АЙМГИЙН

# ЦАСТ АЛТАЙН УГСААТАН

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХОЛБОО

Ховд аймгийн “Цаст Алтайн Угсаатан” аялал жуулчлалын холбоо нийгэмд үйлчлэх ТББ нь 2011 онд байгуулагдсан. Тус холбоо нь Ховд аймаг болон бүс нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж тухайн чиглэлийн сургалт, судалгааны ажил, хөтөлбөрүүдийг зохион байгуулахад нутгийн иргэд, аж ахуйн нэгжийн оролцоо, идэвхийг дэмжих, мэдээллийг хүртээмжтэй хүргэх чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа зохион байгуулдаг ТББ юм.

Удирдах зөвлөл нь Ховд аймагт үйл ажиллагаа эрхэлдэг зочид буудал, жуулчны бааз, амралтын газар, ресторан, аялал жуулчлалын хөтөч компанийн төлөөлөл бүхий 9 гишүүний бүрэлдэхүүнтэй. Сар бүр ажлын тайлан, төлөвлөгөө хэлэлцэн тогтмол хурал хийж үйл ажиллагаа явуулдаг.

[www.travelkhovd.org](http://www.travelkhovd.org)

[www.facebook.com/Ховд-аймгийн-аялал-жуулчлал](https://www.facebook.com/Ховд-аймгийн-аялал-жуулчлал)



# ХОВД АЙМГИЙН “ГУРВАН СЭНХЭР ТӨВТЭЙ ТАВАН ОД”-МАРШРУТУУД

## 1-р маршрут

*/Байгаль, түүх, аялал/*

**Чиглэл нь:**

Гурван Сэнхэрийн агуй - Хар-Ус нуур /55 км/ - Жаргалан хайрхан, Рашаантын хүрхрээ /20 км/ (хоноглох) - Хар нуур /90 км/ - Дөргөн нуур, Жанжин овоо /130 км/ (хоноглох) – Дарви сум /60 км/ – Загал баатрын хиргисүүр /25 км/ – Сутай хайрхан /110 км/ (хоноглох) – Шахаат /55 км/ - Алдар толгой /30 км/ - Цэцэг сум /15 км/ (хоноглох) - Баатархайрхан /120 км/ (хоноглох) – Ишгэн толгойн хадны зураг /80 км/ - Гурван Сэнхэрийн агуй /27 км/

## 2-р маршрут

*/Байгаль, түүх, явганаар аялал/*

**Чиглэл нь:**

Гурван Сэнхэрийн агуй – Баянзүрхийн цогцолбор /130 км/– Бодончийн хавцал /30 км/ (хоноглох) – Алтай сум /80 км/ – Ямаан ус /10 км/ - Тахь ус /70 км/ – 24 эх орончийн хөшөө /70 км/ – Дамжиг ус /60 км/ - Бүдүүн харгайт /45 км/ (хоноглох) – Байтаг /20 км/ – Уушиг уул /30 км/ – Гурван хүүхэд уул /70 км/ – Их Онгогийн тал /45 км/ (хоноглох) – Алаг толгой /55 км/ – Булган сум /10 км/ (хоноглох) – Харуул овоо /25 км/ – Үенчийн хавцал /30 км/ (хоноглох) – Их улаан даваа /70 км/ – Баянзүрхийн цогцолбор /15 км/ – Гурван Сэнхэрийн агуй /130 км/.

## 3-р маршрут

*/Байгаль, түүх соёл, палентлогийн аяллын төрөл/*

**Чиглэл нь:**

Гурван Сэнхэрийн агуй – Манхан сум /20 км/ – Мөнххайрхан сум /70 км/ - Мэлхий хад /10 км/ – Хөх нуурын хүрхрээ /30 км/ (хоноглох) - Шуурхайн хүн чулуу /10 км/ - Долоон нуур /30 км/ (хоноглох) – Мөнххайрхан сум /45 км/ – Дуут /70 км/ – Нэвтийн рашаан /12 км/ (хоноглох) – Гурван Сэнхэрийн агуй /30 км/.

## 4-р маршрут

*/түүх, соёл, шашин мөргөлийн аялал/*

**Чиглэл нь:**

Гурван Сэнхэрийн агуй – Шувуун цуглаан /55 км/ - Ховд хот /35 км/ - Баянбулагийн амралтын газар /30 км/ – Баянбулагийн хиргисүүр /5 км/ - Хөх Сэрхийн нуруу /40 км/ (хоноглох) – Сөртийн хөшөө /25 км/ – Ховд сум /6 км/ (хоноглох) – Шургийн гол /25 км/ – Хөшөөтийн хадны зураг /25 км/ – Цамбагаравын хадны зураг /40 км/ - Цамбагарав уул /20 км/ (хоноглох) – Шижигтийн хавцал /25 км/ – Эрдэнэбүрэн сум /25 км/ – Ховд хотын туурь /30 км/ – Ховд хот /30 км/ – Гурван Сэнхэрийн агуй /100 км/



# ҮЗМЭРҮҮД

## ХОВД АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### ГУРВАН СЭНХЭРИЙН АГУЙ

Ховд аймгийн Манхан сумын төвөөс баруун хойш 25 км-т хойд Сэнхэрийн голын хөндийд Монгол нутагт эртний чулуун зэвсгийн үе, одоогоос 40000 жилийн тэртээ эртний хүмүүс амьдарч байсан ул мөр байна гэсэн дүгнэлтийг эрдэмтэд хийжээ. Манхан сумын Тахилтын бригадаас Хойд Сэнхэрийн голыг өгсөж 7 км яваад гурван Сэнхэрийн агуйд хүрнэ. Уг агуй нь N47°20'50.5", E91°57'24.1" газарзүйн солибцолд, далайн төвшнөөс дээш 1571 метрийн өндөрлөгт оршино. Их, бага хоёр агуйнаас бүрдэнэ. Их агуй зүүн талынхаа хунхад алдарт зургаа хадгалан үлджээ. Агуй нь гантиг чулуунаас тогтсон бөгөөд уулын хормойгоос 100 орчим метрийн өндөрт байрлана. Агуйн дотор талын өндөр нь 15 метр. Тус агуйд янз бүрийн амьтдын зургийг улаан зосоор зурсан хунх 4 бий.

1-р хунх. Уг хунхад 20 гаруй канна гөрөөс, могой тэргүүтнийг зурж үлдээжээ.

2-р хунх. Уг хунх агуйн хамгийн том хунх бөгөөд агуйн хамгийн ур хийц сайтай гоёмсог зургуудыг агуулдаг юм. Хунхад арслан заан, аргаль, тэмээн хяруул, цацагт хяруул, цэн тогоруу, зэрэг амьтдыг дээр дээрээс нь давхарлан гоёмсог байдлаар зуржээ.

3-р хунх. Хоёрдугаар хунхаар дамжин уг хунхад хүрэх бөгөөд уг хунхад зэрлэг тэмээг нилээд том хэмжээгээр чөлөөтэй дүрсэлсэн байхаас гадна янгир, нисэж яваа шувууг дүрсэлсэн байна.

4-р хунх. Энэ хунхад шувуу, гацуур мод, харайж буй гөрөөс зэргийг зурсан байна.





# ҮЗМЭРҮҮД

## ХОВД АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### **ХАР- УС НУУР**

Монголын том нууруудын нэг Хар ус нуур нь 1153 ам километр талбайтай, 72 километр урт, 26 километр өргөн, дундаа аралтай, урд захаараа хулс, шагшуургатай нуур юм. Зэгсний гахай зэрэг ховор амьтадтай, цөлжүү хээр, заримдаг цөлийн нуур бөгөөд Хар нуур, Дөргөн нууруудыг оролцуулан 1997 онд улсын тусгай хамгаалалтанд авсан. Тус цогцолбор газарт 54 зүйлийн хөхтөн амьтан, 268 зүйлийн жигүүртэн шувуу, 455 зүйлийн өвс ургамал, 4 зүйлийн загас, 6 зүйлийн мөлхөгч амьтан, 131 зүйлийн шавьж амьдардгийг тогтоосон байна. Энд хун, бор галуу, төрөл бүрийн цахлай, нугас, зуун хурга, хөх, цагаан дэглий, нэн ховордсон хотон зэрэг шувууд зусна. Хар-Ус нуур хэдийгээр том талбайтай боловч маш цэнгэг устай нуур юм. Хамгийн их гүн нь 4.4 м, дундаж гүн нь 2.0 м юм. Хар ус нуурын хотгор тектоник үүсэлтэй боловч удаан хугацаанаа ширгэж татарснаас эргийн байдал налуу талархаг болсны дээр эргийн зурваст зэгс шигүү ургаж намагжсан байна.





# ҮЗМЭРҮҮД

## ХОВД АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### **МӨНХХАЙРХАН УУЛ**

Мөнххайрхан уул, түүний орчмын газар нутаг нь Баян-Өлгий аймгийн Булган сум, Ховд аймгийн Мөнххайрхан сумын хил залгаа нутгийг дамнан 40-80 километрийн өргөнтэйгөөр баруун хойноос зүүн урагш 200 гаруй километр үргэлжлэн оршдог. Мөнххайрхан уулын ноён оргил нь 4362 метр өндөр бөгөөд мөнх цас мөсөн гол бүхий Монголын хоёр дахь өндөр оргил болно. Мөнх цас, мөсөн гол нь 200-гаад ам километр талбайг эзлэн оршино. Монгол Алтайн нурууны мөсөн голуудын дундаж зузаан нь 56 метр байдаг бол Мөнххайрхан уулын мөсний зузаан нь 130 гаруй метр хүрч тус орны гол мөрний нийлбэр урсацаас бараг 2 дахин, газар доорхи хөдөлгөөнт усны нөөцөөс 5 дахин их цэвэр усны нөөц хадгалагдаж байгааг судлаачид тогтоосон байна. Булган, Сэнхэр, Үенч, Бодонч зэрэг томоохон голууд Мөнххайрхан нуруунаас эх аван урсдаг байна. Мөнххайрхан уулын газар нутагт аргаль угалз, янгир, буга, ирвэс, Алтайн хойлог, ятуу, чоно, мануул, үен суусар, голын халиу, минж зэрэг ан амьтан нутаглахаас гадна хоёр нутагтан мөлхөгчдийн олон төрөл зүйл нэг дор оршдог 4 том тархац нутгийн нэг юм. Монгол улсын Улаан номонд орсон Тойрмын хонин гүрвэл ганцхан Мөнххайрхан уулын дэд мужид бий. Мөн ховорт тооцогддог ногоон бах, үхэрдэй, жунгаарын загас зөвхөн Булган голд бий.





# ҮЗМЭРҮҮД

## ХОВД АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### **БАЯНЗҮРХИЙН БУГАН ХӨШӨӨ**

Ховд аймгийн Мөст сумын нутагт Бодончийн хавцал уруудах замд байдаг Монголын баруун хэсгийн хамгийн томд тооцогдох чулуун дурсгал юм. Баянзүрхийн буган хөшөө нь Мөст сумын төвөөс баруун зүгт 50 гаруй км-т Баянзүрх багийн төвийн орчимд бий. Энд 30 орчим том, жижиг буган хөшөө, хиргисүүр, булш байдаг. Бугын дүрслэл харьцангуй гоёмсог бөгөөд түүний зэрэгцээ 5 өнцөгт дүрс, чичлүүр хутга, бусад зэр зэвсгийг дүрсэлсэн байдаг.

Баянзүрхийн буган хөшөө нь “Тал дахь уран баримлын үзэсгэлэн” мэт сүрлэг бөгөөд Баруун Монгол дахь буган хөшөөний хамгийн том цогцолбор юм. Мөн буган чулуун дээр эдгээр дүрслэлээс гадна эртний хүмүүсийн аж амьдралын сэдэвтэй зураг, бугын загварчилсан зураглал, ирвэс чоно гэх мэтээр бараг бүх амьтныг давхар дүрсэлсэн байдаг. Мөн одоогоор түүхчид тайлж уншиж чадаагүй тэмдэгт дүрсүүд бас байдаг.





# ҮЗМЭРҮҮД

## ХОВД АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### **ТӨРИЙН ТАХИЛГАТ АЛТАН ХӨХИЙ УУЛ**

Ховд аймгийн Мянгад сум, Увс аймгийн Өмнөговь, Өлгий сумын нутгийг дамнан орших үзэсгэлэнт сайхан байгальтай, бие даасан томоохон нуруу юм. Алтанхөхий уул Алтны эх хэмээх газар Алтанхөхий хайрханы баруун энгэр, Ховд голын хөндийд оршдог байна. Нийтдээ 60000 орчим га талбайг эзэлнэ. Алтан Хөхий Өндөр Хөхий овоо 3350 метр өндөрт байдаг. Алтан Хөхийг 250-иад жилийн өмнөөс жил бүр тахиж ирсэн эртний тахилгат овоо юм.

Алтан Хөхийн уулс нь баруун ба өмнүүрээ Ховд голын үзэсгэлэнт өргөн хөндий, хойгуураа мөнх цаст Хархираагийн уулсын өмнүүр уул хоорондын уужим хөндий, зүүн болон урдуураа их нууруудын хотгортой хил залган хөндөлсөнө. Өндөр Хөхийг тойроод Сувагт, Асгат, Дарцагт, Баргалын оргилууд сүндэрлэх ба Алтан, Сонгинот, Улиастайн эгц цавчим хяр хавцлууд, Хүрэн харуул, Нарийн Ангалаг, Шар хамар, Алаг хадат, Пайзат зэрэг хараа сунгасан уужим тэгш өндөрлөг бүхий тал болон Цагаан бургас, Хойд ба Могойн голын эх гээд үзэсгэлэнт газруудтай. Өнтэй, дулаан, соргог сэрмүүн бэлчээртэй өгөөж баян олон зуун өвөлжөө хаваржаа бүхий энэ нутаг бол хүн малын жаргалын орон билээ. Эрдэс баялгийн нөөц ихтэй энд алт, мөнгө, зэс, холимог метал, цахиур, жонш, шохойн чулуу зэрэг ашигт малтмалын илэрцүүд олон буй.



*Nyamdorj.D*



# ҮЗМЭРҮҮД

## ХОВД АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### **ЦАМБАГАРАВ УУЛ**

Цамбагарав уул нь Монгол Алтайн нурууны нэг салшгүй хэсэг бөгөөд ноён оргил Цаст уул нь далайн түвшнээс дээш 4298.4 м өргөгдсөн мөнх цаст уул юм. Цамбагаравын нуруу нь Их Нууруудын хотгорын баруун хойд захад эргэн тойрон хотгор газар, голуудаар хүрээлэгдсэн Монгол Алтайн нурууны зэрэгцээ нуруудад багтдаг. Цамбагарав уулын 110960га талбайг УИХ-ын 2000 оны 29 дүгээр тогтоолоор улсын тусгай хамгаалалтад авчээ. Цамбагаравын нуруунаас эх авсан голууд нийлээд Ховд голд цутгадаг. Мөсдлийн гаралтай цэвэр цэнгэг нуурууд болон олон тооны булаг шанд, рашаануудтай.

Амьтдаас ховордсон аргаль, янгир, ирвэс болон тарвага, зурам, чоно, үнэг, суусар, цагаан үен, хярс зэрэг амьтад нилээд өргөн тархдаг. Шувуудаас хойлог, ятуу, харцага, тас, бүргэд ихтэй. Ирвэс, аргалийг эко бүс нутгийн бэлэг тэмдэг болгон авч үздэг.

Цамбагарав уулын БЦГ нь Евразийн хээрийн муж Алтайн уулын хээрийн хошуу, Монгол-Алтайн хээрийн тойрогт хамаардаг бөгөөд энэ тойрогт 1020 гаруй зүйлийн ургамал бүртгэгдсэний дотор 131 зүйл нь модлог, сөөглөг ургамал, 889 зүйл нь өвслөг ургамал юм. Дундаж өндөр уулсын хажууг дагаж ботуульт, ботууль-жижиг дэгнүүлт үетэн, алаг өвст хээртэй, биелэг өвс, ботууль, ерхөг, дааган сүүл зонхилж, шивээт хялгана, агь бүхий хээр ч тохиолдоно.





# ҮЗМЭРҮҮД

## ХОВД АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### **ХАРУУЛ ОВОО**

Ховд аймгийн Булган сумын төвөөс зүүн урд чигт 15 км-т Үенч сумын төвөөс хойд зүгт 25 км-т Жаргалан нэртэй уулын өвөр, орой дээр нэгэн сүрлэг чулуун байгууламж буйг нутгийнхан Харуул овоо хэмээн нэрлэж иржээ. Хар саарал өнгийн занарлаг чулууг хавтгайгаар нь өрж үелүүлэн энэ овоог босгохдоо дунд зэргийн шургааг модыг 1.5 метрийн зайтайгаар зангилаа углуурга байдлаар бэхэлгээ болгож хийсэн нь модны ил гарсан үзүүрүүдээс харагддаг.

Овоо нь гурван үе бөгөөд доод үеэрээ цүлхгэр бүдүүн, дээшээ нэгэн жигд хэмээр нарийсаж цамхаг хэлбэрээр босгожээ. Овооны өндөр нь 10 гаруй метр орчим, суурийн голч нь 7 метр орчим юм.

Дурсгалын нэрний байдлаас авч үзэхэд уг байгууламжийг нутгийн хил хязгаарын тэмдэг юм уу, ямар нэгэн дохио тэмдэг болгох зорилгоор байгуулсан болох нь тодорхой юм. Энэ дурсгал нь XVII-XVIII зууны үед холбогдох цөөн тооны чулуун байгууламжуудын нэг юм.





# БУСАД ҮЗМЭРҮҮД



## ЯМААН УСНЫ ХАДНЫ СҮГ ЗУРАГ

Ховд аймгийн Үенч, Алтай сумын зааг нутагт Ямаан усны хавцал оршдог. Энэхүү хавцал нь хоёр талаасаа эгц хадан ханаар хашигдсан дундуур нь горхи урсдаг. Уг горхиноос янгир, ямаа ундаалдаг учраас Ямаан ус гэж нэрлэх болжээ. Анх 1973 онд Ховд, Говь-Алтай аймагт ажилласан бичиг үсэг, хадны зураг судлах анги Ямаан-Усны хавцал дахь Ханан хаднаас түрэг бичээс илрүүлжээ. Монголын нутагт 22 газарт түрэг бичээс байгаагийн нэг нь энд байдаг. 10 орчим метрийн өндөр ханан хаданд түүхийн өөр өөр үед холбогдох зургуудыг нэлээд гүн хонхойлон сийлсэн нь 100 гаруй метрийн холоос маш тод харагдах Ямаан-Усны хадны зургийг нийтдээ 4 хэсэг талбайд зуржээ.

## ТАВТЫН ХӨТЛИЙН БУГАН ЧУЛУУН ХӨШӨӨД

Мөст сумын нутаг Тавтын хөтөл дээр 3 буган чулуун хөшөө бий. 1 дэх хөшөөний өндөр 117 см, зузаан 17 см, өргөн 52 см бөгөөд зүүн талд гурван ташуу зураас дүрсэлжээ. Уг хөшөөг хөх саарал өнгийн боржин чулуугаар хийгдсэн. 2 дахь хөшөөний өндөр 120 см, зузаан 18 см, өргөн 50 см бөгөөд цагаан саарал өнгийн боржин чулуугаар хийгдсэн. Доод бүс, урд талд ньнар дүрсэлсэн. 3 дахь хөшөөний өндөр 92 см, зузаан 25 см, өргөн 40 см бөгөөд цагаан саарал өнгийн боржин чулуугаар хийгдэж Дээд бүсийг дүрсэлжээ.

## ИШГЭН ТОЛГОЙН ХАДНЫ ЗУРАГ

Монгол алтайн нурууны ар биеэс эх авсан Урд, Цэнхэр, Дунд, Хойд Сэнхэрийн гурван гол Ховд аймгийн Манхан сумын төвийн орчимд нийлж урсах ба түүний хойд талынхныг Ишгэн толгой гэнэ. Манхан сумын төвөөс хойш 6 км орчимд жижиг хадан толгой оршино. Цэнхэрийн голын хөндийд хүн эрт цагаас нутаглан ан гөрөө хийж амьдарч өөрсдийн хийж хэрэглэж байсан хөдөлмөрийн багаж зэвсэг төдийгүй урлан бүтээсэн урлаг соёлын гайхамшигт дурсгалаа үлдээжээ. Ишгэн толгойн хаднаа үхэр, адуу, буга, янгир, тэмээ зэрэг амьтдын дүрсийг хадны толио дээр энд тэнд гол төлөв ганц нэгээр толгойг дуртай зүг рүүгээ харуулан урласан бөгөөд зургийн сийлбэрийн өнгө хадны байгалийн өнгөнөөс бараг ялгарахгүй болж зөвхөн гараар тэмтрэхэд сийлбэртэй болох нь мэдэгдэх төдий буйгаас үзэхэд эдгээр зураг нь нэлээд эртний болох нь тодорхой.







# АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГУУД

СУТАЙ ХАЙРХАН ОРЧМЫН БААЗУУД

©fb.com/ErdenebulganPhotographer



## СУТАЙ ХАЙРХАН

📍 Ховд аймгийн  
Дарви сум

☎ 98140410  
99662973

🌐 facebook.com/сутай хайрхан эко бааз

📄 lounge.resistors.showroom  
46.2729° N, 102.7790° E



## СУТАЙ ТУР

📍 Ховд аймгийн  
Дарви сум

☎ 99479900  
99819391

🌐 facebook.com/Сутай Амралт- Жуулчны Бааз

📄 lounge.resistors.showroom  
46.2729° N, 102.7790° E



## ДӨРГӨН ХАТАН

📍 Ховд аймгийн  
Чандмань сум

☎ 95117677  
95110307

🌐 facebook.com/durgun khatan tour

📄 lounge.resistors.showroom  
46.2729° N, 102.7790° E



# ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУД



## ХОВД ХОТЫН ЗООГИЙН ГАЗРУУД



### ТАЛЫН БУУДАЛ

📍 Ховд аймгийн  
Ховд хот

☎ 70439999, 89111878

📘 Монгол, Европ, Ази хоол  
[www.facebook.com/steppehotel](http://www.facebook.com/steppehotel)

📍 lounge.resistors.showroom  
46.2729° N, 102.7790° E



### МИНЖ

📍 Ховд аймгийн  
Ховд хот

☎ 99215570

📘 Монгол хоол  
[www.facebook.com/minjkhovd](http://www.facebook.com/minjkhovd)

📍 lounge.resistors.showroom  
46.2729° N, 102.7790° E



### ӨРГӨӨ

📍 Ховд аймгийн  
Ховд хот

☎ 99064306

📘 Европ, Ази хоол  
[www.facebook.com/urguukhovd](http://www.facebook.com/urguukhovd)

📍 lounge.resistors.showroom  
46.2729° N, 102.7790° E



# ЭВЭНТ БАЯР НААДМУУД

## ЦАЙНЫ ЗАМ

Олон угсаатны соёлын биет болон биет бус өв, язгуур урлаг, цайны соёлыг өвийг өвлүүлэн үлдээх, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх замаар аялал жуулчлалаас орох эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор жил бүр уламжлал "Цайны зам" өв соёлын наадмыг зохион байгуулдаг.

### ХУГАЦАА:

9 дүгээр сарын 25-28

### ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ГАЗАР:

Ховд хот

### ХӨТӨЛБӨР:

- Уран нугаралтын уралдаан
- Олон угсаатны өв соёлын үзүүлбэр тоглолтууд
- Цайны өв соёлыг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх арга хэмжээ
- "Тэмээн жин тээх" болон Монгол нүүдэл
- Эрийн гурван наадам
- Ховдод үйлдвэрлэв үзэсгэлэн худалдаа
- гэрэл зураг, уран зургийн дуудлага худалдаа
- Адуучин тэмцээн
- "Цайны зам" эрдэм шинжилгээний бага хурал
- "Нүүдлийн шувуудын диваажин" аялал хийх



## МӨНГӨЛӨГ ШАГШУУРГА ӨВЛИЙН НААДАМ

Гурван Сэнхэр төвтэй таван од аялал жуулчлалын хөтөлбөр"-ийн хүрээнд Баруун Монголын угсаатны онцлог төрхийг хадгалсан аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг бий болгох, байгаль дэлхий, үндэсний өв соёлоороо бахархах, өвлийн аялал жуулчлал, нийтийн биеийн тамирын спортыг хөгжүүлэх, гадаад, дотоодын жуулчдын тоог нэмэгдүүлэх замаар орон нутгийн эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр нэмэгдүүлэхэд оршино.

### ХУГАЦАА:

1 сарын сүүлийн өдрүүдэд

**ХААНА:** Хар-Ус нуурын "Төмөрт" хэмээх газарт /Шувуу ажиглах цамхаг/

### ХӨТӨЛБӨР:

- Баруун бүсийн аварга шалгаруулах тэшүүрийн тэмцээн
- Аймгийн аварга шалгаруулах мөсөн сурын харваа
- Насанд хүрэгчдийн олс таталтын тэмцээн
- Насанд хүрэгчдийн сумо бөхийн тэмцээн /Эрэгтэй/
- Бүх нийтийн кросс гүйлтийн тэмцээн /Эрэгтэй эмэгтэй/

